

ЧАДВАРЛАГ ОЮУТАН-2022 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС “ЧАДВАРЛАГ ОЮУТАН-2022” Анагаахын оюутны эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 11 сарын 25-ны өдөр Сайншанд хотод амжилттай зохион байгууллаа.

Хурлын үйл ажиллагааг нээж АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн захирал БУ-ын доктор М.Отгончимэг үг хэлэв.

Хуралд зочин илтгэгчээр АШУҮИС. АУС-ийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхимийн багш, Монголын Эх барих эмэгтэйчүүд, Нярай судлалын Холбооны Тэргүүн, АШУҮИС-ийн дэргэдэх Судлаач Оюутны Клубийн удирдагч АУ-ны доктор, Дэд профессор, Монгол улсын Зөвлөх эмч Б.Жаргалсайхан “Монгол судлаач оюутнуудын хувь хүний хөгжил багийн амжилтын үндэс болох нь”, Япон улсын Шига Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургууль, Эм судлалын тэнхимийн судлаач АУ-ны магистр Б.Мэнд-Амар NRDC regulates aortic contraction, илтгэл хэлэлцүүлж, АШУҮИС-ийн НЭМС-ийн Биостатистикийн тэнхимийн эрхлэгч, Дорноговь салбар АУС-ийн Эрдэмтдийн зөвлөлийн гишүүн АУ-ны доктор, дэд профессор Д.Гантуяа Судалгааны арга зүй лекц уншлаа.

Мөн АШУҮИС-ийн дэргэдэх Судлаач Оюутны Клубийн оюутнууд, БАС-ийн судлаач оюутнууд танхимаар оролцлоо.

Чадварлаг оюутан-2022 эрдэм шинжилгээний хурлын 1-р шатанд АШУҮИС-ийн Эрдмийн сургууль, АУС, БАС, Сувилахуйн сургууль, Эм зүйн сургууль, МАУОУС, НЭМС, Дорноговь салбар АУС, Дархан-Уул салбар АУС, Говь-Алтай салбар АУС, Ач АУС, Их засаг ОУИС зэрэг 12 сургуулийн оюутнууд оролцож 60 гаруй илтгэл ирүүлсэн байна.

Хурлын даргаар АШУҮИС-ийн Дорноговь салбар АУС-ийн багш АУ-ны доктор, клиникийн профессор Х.Удвал, Дорноговь салбар АУС-ийн ЭШМТА-ны дарга АУ-ы магистр Д.Сансармаа, хурлын шүүгчээр Дорноговь салбар АУС-ийн багш БУ-ны доктор, дэд профессор Д.Баатар, АУ-ны доктор, клиникийн профессор Ц.Сарантуяа, БУ-ны доктор Л.Янжинсүрэн нар ажиллаж, 2-р шатанд 16 илтгэлийг хэлэлцүүлэн шалгаруулав.

Тэргүүн байранд АШУҮИС-ийн Био Анагаахын Сургуулийн АСБД-ны оюутан Ц.Хичээнэ нарын “Ургийн нүүрний хэлбэрших үйл явцыг судалсан үр дүн”, Дэд байранд АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн оюутан С.Цээлээ нарын “Ковид-19 халдварын цар тахлын үеийн эмчилгээнд хэрэглэгдэж буй Монголын уламжлалт Мана-4, Норов-7 тангуудын үр дүнгийн талаарх харьцуулсан судалгаа”, Гутгаар байранд АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургуулийн оюутан, АШУҮИС-ийн дэргэдэх Судлаач клубын тэргүүн Б.Мөнхтуяа нарын “КОВИД 19-ийн халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн цусны бүлэгнэлтийн тогтолцоонд гарах өөрчлөлтийг судалсан нь” илтгэлүүд шалгарлаа.

Чадварлаг оюутан 2022 эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож шагналт байранд шалгарсан оюутнууд болон бидний зохион байгуулсан эрдмийн хуралд бүтээлээ ирүүлж хэлэлцүүлсэн судлаач оюутнууд, судалгааны багийн хамт олон, чиглүүлэгч багш нартаа баярлалаа. Та бүхний сурлага, хөдөлмөр, судалгаа шинжилгээний ажилд нь амжилт хүсье.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБА

